



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

## ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 СУУРЬ БОЛОВСРОЛ



# ФИЗИК

*ХУВИЛБАР А*

Аймаг / дүүрэг: .....

Сум / сургууль: .....

Анги / бүлэг: .....

Сурагчийн овог: .....

Сурагчийн нэр: .....

Сурагчийн код: .....



### САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

1. Далбаат тэргэнцрийг зурагт үзүүлэв. Сэнсээр үлээхэд тэргэнцэр хөдөлнө. Тэргэнцрийг хөдөлгөөнд оруулж байгаа шалтгааныг нэрлэнэ үү.

- A. салхи
- B. тэргэнцэр
- C. дугуй
- D. дарвуул



2. Сурагч орой хичээлээ хийхээр ширээний чийдэнгээ асаалаа. Ширээний чийдэн асаалттай байх үед цахилгаан энерги ямар энергийн хэлбэрүүдэд хувирсан бэ?

- A. Цахилгаан ба хөдөлгөөний энерги
- B. Хөдөлгөөн ба гэрлийн энерги
- C. Дулаан ба цахилгааны энерги
- D. Гэрэл ба дулааны энерги

3. Дараах харилцан үйлчлэлийн хэлбэрүүдээс алинд нь татах хүч үйлчилж байна вэ?

A.

B.

C.

D.








4. Цонхоор бөмбөг шидвэл дэлхийн татах хүчний улмаас доош унадаг. Энэ унах хөдөлгөөн хурдсах учир газрыг их хурдтайгаар мөргөнө. Гэтэл онгоцноос шүхэрчин үсэрвэл доош унах боловч тийм ч их биш хурдтай газардаж чаддаг. Шүхэрчний хурд яагаад багассан бэ?

- A. Дэлхийн татах хүчний нөлөөгөөр
- B. Тулгуурын хүчний нөлөөгөөр
- C. Агаарын эсэргүүцлийн хүчний нөлөөгөөр
- D. Биеийн хүчний нөлөөгөөр



5. Бөмбөг шалан дээр өнхөрч байгааг зурагт харуулав. Аль зурагт түүнд үйлчлэх хүндийн хүчийг зөв дүрсэлсэн байна вэ?



A.


B.

C.

D.





6. Зурагт ачаа зүүгээгүй, 100 г масстай ачаа зүүсэн, үл мэдэгдэх масстай ачаа зүүсэн нэгэн төрлийн пүршийг харуулав. 100 г масстай ачаатай пүрш тэнцвэрийн байрнаас ойролцоогоор

20 см сунасан бол үл мэдэгдэх масстай ачаатай пүрш тэнцвэрийн байрнаас ойролцоогоор 30 см сунасан байна. Үл мэдэгдэх ачааны массыг ол.



- A. 50 г      B. 100 г      C. 150 г      D. 200 г


7. Дараах зургуудаас аль нь гэрэл ойлтыг харуулсан бэ?

A	B	C	D
Наран цаг	Толь	Томруулдаг шил	Солонго
			


8. Гэрэл нэвтрүүлдэг биетийг сонгоорой.

- A. Нимгэн цаасан хуудас      B. Нимгэн шилэн ялтас  
C. Нимгэн төмөр хавтан      D. Нимгэн модон хавтан

9. Төрөө, Хүслэн нар Өнхрүүш үлгэрээр сүүдрийн жүжиг тоглуулжээ. Өнхрүүшийг үнэгний дүрсээс жижиг харагдуулахын тулд аль байрлалд байрлуулах вэ?




10. Гэрлийн үндсэн гурван өнгө: Улаан, ногоон, хөх. Эдгээрийг холиход өөр өөр өнгө үүсдэг. Энэ үүссэн өнгийг завсрын өнгө гэдэг. Ягаан өнгө аль хэсэгт үүсэх вэ?




- A. 1  
B. 2  
C. 3  
D. 4

11. Зурагт хүүхэд, гэрлийн чийдэн, бөмбөгийн байрлалыг харуулав. Гэрлийн цацраг ямар дарааллаар туссанаар хүүхэд бөмбөгийг харж байгаа бэ?




- A. Гэрлийн чийдэн → хүүхдийн нүд → бөмбөг  
B. Хүүхдийн нүд → гэрлийн чийдэн → бөмбөг  
C. Бөмбөг → гэрлийн чийдэн → хүүхдийн нүд  
D. Гэрлийн чийдэн → бөмбөг → хүүхдийн нүд

12. Зураг дээр хавтгай толины шинж чанарыг судлах туршилтыг үзүүлэв. Аль нь туршилтын үр дүнгийн зөв таамаглал вэ?



- A. А лааны дүрс толинд үүсэхгүй.  
B. А лааны хуурмаг дүрс бол Б юм.  
C. А лааны сүүдэр Б лаа юм.  
D. Б лааг тод харахын тулд туршилтыг маш их гэрэлтэй орчинд хийх хэрэгтэй.

13. Тунгалаг орчноос гэрлийн цацраг ус руу нэвтэрсэн зургийг харуулав. Хүснэгтээс тусгалын өнцөг, хугарсан цацраг, нормаль шулууныг зөв тодорхойлсон мөрийг олно уу.




	Тусгалын өнцөг	Хугарсан цацраг	Нормаль шулуун
A.	I	V	III
B.	II	V	III
C.	V	I	II
D.	IV	II	V

14. Халуун бие орчин тойрноо халаах чадвартай байдаг. Иймд халуун бие энергитэй байна. Энергийн ийм хэлбэрийг дулааны энерги гэдэг. Дараах зургаас аль нь дулааны энергитэй байна вэ?



- A. Халаагуур ба буцалж буй ус  
B. Халаагуур ба батарей  
C. Хадаас хадах ба батарей  
D. Буцалж буй ус ба хадаас хадах

15. Төгсөө биеийн тамирын зааланд өмсөх гутлаа сонгохын тулд туршилт хийжээ. Тэр хүч хэмжигч ашиглан зүүн тийш татжээ. Үрэлтийн хүч аль чиглэлд үйлчлэх вэ?




- A. зүүн тийш  
B. баруун тийш  
C. дээш  
D. доош

16. Автомашинны өвлийн дугуй арзгар хээтэй байдаг. Үүний учир нь юу вэ?



- A. Үрэлтийг ихэсгэх  
B. Үрэлтийг багасгах  
C. Масс ихэсгэх  
D. Масс багасгах

17. Доорх зурагт өгсөн биеүдийн тулгуурын хүчнүүдийг жишнэ үү.




- A.  $I=III>II$   
B.  $I>II>III$   
C.  $II>III>I$   
D.  $II>I=III$

18. Зурагт улайсах чийдэнгийн энергийн хувирлыг илэрхийлсэн диаграмм өгөгджээ. Улайсах чийдэнгийн үр ашиггүй ямар энергийн хэлбэрийг ялгаруулсан бэ?



- A. Дулааны энерги                      В. Гэрлийн энерги  
C. Дууны энерги                        D. Цахилгаан энерги

19. Хавтгай толинд дүрс тэгш хэмтэй үүсдэг. Биетийн дүрсийг аль нь зөв дүрсэлсэн байна вэ?



20. 6-р ангийн сурагчид Монгол улсад хэдэн төрлийн цахилгаан станц байдгийг судалсан судалгааны үр дүнг дараах зургуудад харуулав. Цахилгаан станцуудын эрчим хүч үйлдвэрлэлийн аль нь сэргээгдэхгүй эрчим хүчийг ашигладаг вэ?

A	Говь-Алтай аймаг Тайшир усан ЦС	
B	Төв аймаг Салхит салхин ЦС	
C	Говьсүмбэр аймаг Сүмбэр нарны ЦС	
D	Улаанбаатар хот Дулааны 4-р ЦС	